



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 11 дүгээр сарын 18  
№ 45 (1243)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

788. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 64 3079

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

789. Анхан шатны шүүхийн шүүгчийн  
албан тушаалд томилох тухай Дугаар 154 3080

790. Анхан шатны шүүхийн шүүгчийн  
албан тушаалд томилох тухай Дугаар 155 3080

791. Шүүгчийн албан тушаалаас  
чөлөөлөх тухай Дугаар 157 3081

792. Шүүгчийн албан тушаалаас  
чөлөөлөх тухай Дугаар 158 3081

793. Эзэн Богд Чингис хааны эш хөргийг  
хүндэтгэн залах тухай Дугаар 159 3082

794. Шүүгчийн албан тушаалаас  
чөлөөлөх тухай Дугаар 166 3083

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

795. Журам батлах тухай Дугаар 211 3083





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 11 дүгээр  
сарын 03-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**Mongolian Folio\_02 Ukhaa Noriga 02 Davslegda**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ  
ᠬᠤᠷᠠᠯ ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ  
ᠲᠤᠨ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ  
ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ  
ᠬᠤᠷᠠᠯ ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ  
ᠲᠤᠨ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ  
ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ  
ᠬᠤᠷᠠᠯ ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ  
ᠲᠤᠨ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ  
ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ  
ᠬᠤᠷᠠᠯ ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ  
ᠲᠤᠨ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ  
ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ  
ᠬᠤᠷᠠᠯ ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ  
ᠲᠤᠨ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ  
ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ ᠠᠨᠠᠭ



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 154

Улаанбаатар  
хот

### Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 217 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Уртнасангийн Сайнбилэгийг Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 155

Улаанбаатар  
хот

### Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 218 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Амгалансүрэнгийн Мөнх-Өлзийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 157

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн 40.2.9 дэх заалт, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 208 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн Цэрэннадмидын Батсүрэнг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 158

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн 40.2.9 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 209 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн Чимэдцэрэнгийн Ичинхорлоог Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 159

Улаанбаатар  
хот

### Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай

Эдүгээгээс 860 жилийн тэртээ дэлхийн түүхийн мянганы суут хүмүүн Тэмүүжин мэндэлж, төрт ёс, түүх соёл, хууль цаазын дор Монгол туургатныг нэгтгэн, өнө эртнээс уламжлалтай төрт улсаа сэргээн мандуулж, Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол Улсыг байгуулан, Монголын Эзэнт гүрний сүр хүчийг тунхаглан, Монгол үндэстний суу алдрыг бадраасан Эзэн Богд Чингис хаан болон өргөмжлөгдөж, дэлхий дахинд Монголын их амар амгалан (Pax Mongolica)-г тогтоосон билээ.

Эзэн Богд Чингис хааны суу алдар, агуу их түүхэн үйл хэргийг сурвалжлан судлах, түгээн дэлгэрүүлэх, эрхэмлэн дээдлэх, алдаршуулан мөнхжүүлэх, төрт ёсны үнэт өвийг бэхжүүлэх, эв зөгийг бататгах үүднээс Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Нэг.Эзэн Богд Чингис хааны эш хөргийг Монгол төр эрхэмлэн дээдэлж Төрийн ордонд залсугай.

Хоёр.Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай.

Гурав.Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай.

Дөрөв.Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв зөө сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 166

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, мөн зүйлийн 40.2 дахь хэсгийн 40.2.9 дэх заалт, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 81 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн Чулууны Тунгалагийг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалаас, Дарамын Мягмаржавыг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас, Цэнд-Аюушийн Ичинхорлоог Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас, Батбаярын Оюуныг Дорнод аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар  
сарын 31-ний өдөр

Дугаар 211

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9.16-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хязгаарлалттай мэдээллийг өгсөн, дамжуулсан тохиолдолд мэдээллийн эзэнд мэдэгдэл хүргүүлэх, ашиглах хүсэлт гаргасан, гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан талаарх бүртгэл хөтлөх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.





2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Х.НЯМБААТАР**

Засгийн газрын 2022 оны 211 дүгээр  
тогтоолын хавсралт

**ХЯЗГААРЛАЛТТАЙ МЭДЭЭЛЛИЙГ ӨГСӨН, ДАМЖУУЛСАН  
ТОХИОЛДОЛД МЭДЭЭЛЛИЙН ЭЗЭНД МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ,  
АШИГЛАХ ХҮСЭЛТ ГАРГАСАН, ГУРАВДАГЧ ЭТГЭЭДЭД ӨГСӨН,  
ДАМЖУУЛСАН ТАЛААРХ БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЖУРАМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмын зорилго нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9.13, 9.14-т заасны дагуу хязгаарлалттай мэдээллийг ашигласан, гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан тохиолдолд мэдээлэл хариуцагч энэ тухай мэдээллийн эзэнд мэдэгдэл хүргүүлэх, мэдээлэл хариуцагч хязгаарлалттай мэдээллийг ашиглах хүсэлт гаргасан, гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан талаарх бүртгэл хөтлөхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журмын 1.1-д заасны дагуу мэдэгдэл хүргүүлэх, бүртгэл хөтлөхөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримтална.

**Хоёр.Мэдэгдэл хүргүүлэх**

2.1.Мэдээлэл хариуцагч нь хязгаарлалттай мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9.13-т заасны дагуу төрийн байгууллага болон хуульд заасан бусад этгээдэд хуульд заасан үндэслэл, журмын дагуу өгсөн, дамжуулсан бол энэ тухай мэдээллийн эзэнд тухай бүр мэдэгдэнэ.

2.2.Мэдээлэл хариуцагч Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9.19-д зааснаас бусад тохиолдолд мэдээллийн эзэнд мэдэгдэл хүргүүлэх бөгөөд мөн хуулийн 23 дугаар зүйлд заасан мэдэгдэл хүргэх системийг ашиглана.



2.3.Мэдэгдэл хүргэх системийн үйл ажиллагааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 32.1.15-т заасны дагуу цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулж, хяналт тавина.

2.4.Мэдэгдэлд дараах мэдээллийг тусгана.

2.4.1.мэдээлэл авсан зорилго;

2.4.2.мэдээлэл авагч нь хувь хүн бол эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, холбоо барих хаяг, харилцах утасны дугаар;

2.4.3.мэдээлэл хариуцагчийн нэр, холбоо барих хаяг, харилцах утасны дугаар;

2.4.4.авсан мэдээллийн жагсаалт, мэдээлэл авсан хэлбэр;

2.4.5.мэдээллийг өгсөн он, сар, өдөр;

2.4.6.тухайн мэдээллийг авах хууль зүйн үндэслэл.

2.5.Энэ журмын 2.1-д зааснаас бусад үндэслэлээр мэдээлэл хариуцагчаас мэдэгдэл хүргэхтэй холбоотой харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

2.6.Энэ журмын 2.1, 2.5-д заасны дагуу мэдээлэл хариуцагчаас мэдэгдэл хүргэхэд энэ журмын хавсралтаар баталсан маягыг ашиглана.

### **Гурав.Хязгаарлалттай мэдээлэл ашиглах хүсэлтийг бүртгэх**

3.1.Хүн, хуулийн этгээд нь хязгаарлалттай мэдээлэл ашиглах хүсэлтээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 13.2-т заасны дагуу бичгээр гаргана.

3.2.Хязгаарлалттай мэдээлэл ашиглах хүсэлт нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 13.4-13.8 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

3.3.Мэдээлэл хариуцагч энэ журмын 3.1-д заасан хүсэлтийг бүртгэхэд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан мэдээлэл солилцооны бүртгэлийн системийг ашиглах бөгөөд тус бүртгэлд дараах мэдээллийг тусгана:

3.3.1.хүсэлт гаргасан хүн, хуулийн этгээдийн нэр, харилцах утасны дугаар, хаяг;

3.3.2.хүссэн мэдээллийн товч агуулга, зорилго;

3.3.3.хүсэлт хүлээн авсан он, сар, өдөр, хэлбэр;

3.3.4.хүсэлтийг буцаасан тохиолдолд үндэслэл, хэлбэр;

3.3.5.хууль зүйн үндэслэл;

3.3.6.шаардлагатай бусад.

**Дөрөв.Хязгаарлалттай мэдээллийг гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан талаарх бүртгэл хөтлөх**

4.1.Мэдээлэл хариуцагч хязгаарлалттай мэдээллийг гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан талаарх бүртгэл хөтлөх бөгөөд тус бүртгэлд дараах мэдээллийг тусгана:

4.1.1.хүсэлт гаргасан этгээдийн мэдээлэл;

4.1.2.мэдээллийг өгсөн, дамжуулсан он, сар, өдөр;

4.1.3.мэдээллийн эзнийг тодорхойлох мэдээлэл;

4.1.4.мэдээллийн эзний зөвшөөрөл шаардахаар хуульд заасан тохиолдолд түүний зөвшөөрөл өгсөн хэлбэр;

4.1.5.зөвшөөрлийн баталгаажуулалт хийсэн он, сар, өдөр;

4.1.6.хүсэлт гаргагчийг цахим тодорхойлогчоор тогтоосон тодорхойлолт;

4.1.7.байгууллага, албан тушаалтны хандсан он, сар, өдөр;

4.1.8.авсан мэдээллийн агуулга;

4.1.9.мэдээлэл авсан зорилго;

4.1.10.мэдээлэл ашигласан этгээд нь хувь хүн бол эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, албан тушаалтны эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, харилцах утасны дугаар;

4.1.11.мэдээллийг бүрэн, эсхүл хэсэгчлэн өгсөн эсэх;

4.1.12.өгсөн, дамжуулсан мэдээллийн жагсаалт, мэдээлэл авсан хэлбэр;



4.1.13.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9.12-т заасан этгээд байх тохиолдолд тухайн мэдээллийг авах хууль зүйн үндэслэл;

4.1.14.шаардлагатай бусад.

4.2.Мэдээлэл хариуцагч нь хязгаарлалттай мэдээллийг гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан мэдээллийг бүртгэхэд энэ журмын 3.3-т заасан системийг ашиглана.

### **Тав.Бусад зүйл**

5.1.Энэ журмын 1.1-д заасны дагуу мэдэгдэл хүргүүлэх, бүртгэл хөтлөхөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан нийтийн мэдээллийн дэд бүтцээс өөр хэлбэр, арга хэрэгслийг ашиглахыг хориглоно.

---oOo---

Хязгаарлалттай мэдээллийг өгсөн, дамжуулсан тохиолдолд мэдээллийн эзэнд мэдэгдэл хүргүүлэх, ашиглах хүсэлт гаргасан, гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан талаарх бүртгэл хөтлөх журмын хавсралт

### **МАЯГТ.МЭДЭЭЛЛИЙН ЭЗЭНД ХҮРГЭХ МЭДЭГДЭЛ**

| Мэдээлэл хариуцагч байгууллага | Мэдээлэл ашигласан байгууллага | Үндэслэл (хуульд заасан, эсхүл мэдээллийн эзэн зөвшөөрсөн) | Дамжуулсан мэдээлэл | Огноо |
|--------------------------------|--------------------------------|--|---------------------|-------|
|                                |                                |  |                     |       |
|                                |                                |  |                     |       |
|                                |                                |  |                     |       |

\*Танд тодруулах зүйл байвал мэдээлэл ашигласан байгууллагад хандана уу.

Мэдэгдэл хүргэх систем

---oOo---



**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [tugii\\_medeel@parliament.mn](mailto:tugii_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

**Индекс: 200003**